

Гоёмсог хосууд

Тус бүр нь N ширхэг элемент бүхий A ба B массивууд өгөгдөв. Тэгвэл A массивын ямар нэг i дугаартай элемент,

B массивын ямар нэг j дугаартай элементтэй тэнцүү бол тэдгээрийг гоёмсог хосууд гэдэг.

Өөрөөр хэлбэл $A[i]=B[j]$ байна гэсэн үг. Ингэхдээ нэг элементийг нэг удаа л хос болгон ашиглана гэсэн үг.

Жишээ нь: $A=[10, 11, 12, 5, 14]$ $B=[8, 9, 11, 11, 5]$ үед $[1, 2]$, $[1, 3]$, $[3, 4]$ гэсэн байдлаар элементийг давтан ашиглахгүй.

Тэгвэл B массивын яг нэг ширхэг элементийг өөрчлөөд хамгийн ихдээ хэдэн ширхэг элементтэй гоёмсог хосууд үүсгэж болохыг тооцоолно уу.

Оролтын хэлбэр:

Эхний мөрөнд A ба B массивын элементийг тоог илэрхийлэх N тоо

Хоёрдугаар мөрөнд A массивын элементүүд болох N ширхэг тоонууд

Гуравдугаар мөрөнд B массивын элементүүд болох N ширхэг тоонууд зайгаар тусгаарлагдан тус тус өгөгдөнө.

Хязгаарлалт:

$1 \leq N \leq 1000$,

$1 \leq A[i], B[i] \leq 1000$.

Гаралтын хэлбэр:

Өгсөн нөхцөлийг ханган үүсгэж болох хамгийн их хосын тоог хэвлэнэ.

Санамж: Хамгийн гол нь B массивын яг нэг ширхэг элементийн утгыг өөрчлөн үүсгэж болох хамгийн олон хосуудын тоог олно.

Жишээ Оролт 0

4

1 2 3 4

1 2 3 3

Жишээ Гаралт 0

4

Тайлбар 0

B массивын 3 дахь юм уу 4 дэх элементүүдийн аль нэгийг 4 болгосноор 4 ширхэг гоёмсог хосуудыг үүсгэж чадна.

Орчуулсан : Хөвсгөл аймгийн Ирээдүй сургуулийн багш Д.Батмөнх